



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 245

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг  
шинэчлэн тогтоож, балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 17,550,000.00 (арван долоон сая таван зуун тавин мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 8,100,000.00 (найман сая нэг зуун мянга) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газар ("Хилийн цэргийн 0119 дугаар анги" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар)-т балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн, Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын дарга Ж.Тамир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005475  
14-r\_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны ... дугаар сарын ... өдрийн  
 ... дугаар тогтоолын хавсралт

ТӨР ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ, АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ  
 ШИНЭЧЛЭН ТОГТООЖ ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ  
 ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашигдах жил
1	Сандал ногоон бүрээстэй төмөр	2002/10/01	270	65,000.00	17,550,000.00	30,000.00	8,100,000.00	2
Нийт дүн								
					17,550,000.00 (арван долоон сая таван зуун тавин мянга)		8,100,000.00 (найман сая нэг зуун мянга)	